



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 62

Номгон

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн
түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 2 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Баянлиг, Бууцагаан сумдын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 2014 онд ашиглалтад орсон Уурын зуух, шугам сүлжээ, тоног төхөөрөмжүүдийг түрээсээр ашиглуулсугай.

2. Аймгийн Засаг дарга Г.Батжаргалд ДААЛГАХ нь:

2.1 Түрээсээр ашиглуулах эд хөрөнгийн зориулалтыг нь өөрчлөхгүйгээр хууль журмын дагуу түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсэг байгуулсугай.

2.2 Түрээслэх эд хөрөнгийн талаарх танилцуулга мэдээллийг бэлтгэх, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд зарлаж, хууль журмын дагуу сонгон шалгаруулалтыг явуулсугай.

2.3 Эд хөрөнгийн түрээслэгчийн сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу хэрхэн зохион байгуулсан талаарх тайлангаа аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд энэ оны II улиралд багтааж танилцуулсугай.


2.4 Түрээслүүлсэн эд хөрөнгийн түрээсийн орлогыг Орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлсүгэй.

3. Орон нутгийн өмчийг түрээслэх, худалдах, олж авах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай журмуудыг шинэчлэн боловсруулж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ч.Мөнхцэцэг/-д даалгасугай.

0117005

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д даалгасугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР